



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын хоёрдугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Батцогт

Утас: 70342716 Цахим хаяг: @audit.gov.mn

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит
ХХК-ийн

Гүйцэтгэх захирал С.Оргил

Утас: 99197346

Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5-9
3. АУДИТЫН ТАЙЛАН	10
4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12-15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БГ	Боловсролын газар
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Аялдагчдын өргөн чөлөө 1-120, Жаргалант, 3-р баг, Булган сум, Булган аймаг, 63082, Утас/Факс: 7034-2580 Цахим шуудан: bulgan@audit.gov.mn 2026.09.24 № 187 Танай _____ ны № _____ Т	БУЛГАН СУМЫН ХОЁРДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.МЯГМАРЦЭНД ТАНАА
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<p>Санхүүгийн тайланд хийсэн аудитаар:</p>	
<ul style="list-style-type: none">• Цэцэрлэгийн хоол хүнсний материал нэг хүүхдэд ногдох нормыг тогтмол бариулаагүй, бүлгийн журнал хөтлөлт, няравын өдөрлөгийн бүртгэл хөтлөлт, зөрүүтэй, гал тогооны бүртгэл байхгүй, хагас жил, жилийн эцсийн тайлангаар төсвийг 7,8 сая төгрөгөөр илүү зарцуулсан,• Нэр бүхий 11 бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүст бараа материалын тооцоо нийлсэн акт үйлдээгүйгээр 5.2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн,• Тайлант оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын Нийгмийн даатгалын тайлангаар даатгуулагчийн код 1.8 сая төгрөгөөр алдаатай тайлагнасан,• 2 дугаар сард нийт 14 багш нарын илүү цагийг бодохдоо илүү цаг бодох журмын хүрээнд тооцоолоогүй, 2 хувиар бодож, 0.5 хувиар илүү тооцож 1.4 сая төгрөг илүү олгосон,• 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр нийт 115 төрлийн бараа материалын данснаас материалыг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн шийдвэр, эрхлэгчийн тушаал байхгүйгээр 11.5 сая төгрөгийн шууд зарлага гаргасан,• Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд орногод тусгасан, Булган сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн гал тогооны төхөөрөмжийг хүлээн авсан актгүй, орлого авах шийдвэргүй 4 дүгээр сард нийт 21.8 сая төгрөгөөс 2.0 сая төгрөгийн хүлэмжийг бараа материалын дансанд	
6326050463	

бүртгэсэн,

- Жилийн эцсийн тооллого хийгдээгүй, тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тайлан тус бүрийн орлого, заргаа дутуу тайлагнасан, сарын тайлангууд гараагүй программд буруу тайлагнасан,
- Нягтлан бодогч Э.Одгэрэл нь 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөр, багшийн туслах ажилтан Г.Одгариг нь 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгон ажлаас чөлөөлөгдсөн байтал 12 дугаар сард бүтэн цалин олгож 1.9 сая төгрөгийг илүү олгосон,
- ХХОАТ-ын тайлангийн даатгуулагчын НДШ, цалин хөлсний тооцооны хүснэгт дэх НДШ 12.1 сая төгрөгөөр зөрүүтэй зэрэг нийт 63.8 сая зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган аймгийн Булган сумын 2 дугаар цэцэрлэгийн түр орлон гүйцэтгэгч нь Булган аймгийн боловсролын газрын даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлгээний төлөвлөгөө нь 5 зорилт, 35 арга хэмжээний хүрээнд 92.5 хувиар үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

2025 онд 186 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 186 хүүхэд үндсэн цэцэрлэгт, хувилбарт хөтөлбөрт хүүхэд хамрагдаагүй гүйцэтгэлээр 100 хувь санхүүжигдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular stamp containing a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style. To the right of the signature, the name 'Д.БАТЦОГТ' is printed in red. The stamp also contains some vertical Mongolian text on the left side, which is partially obscured by the signature.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	252,380,712.39	174,146,366.69
2	31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	128,378,875.21	64,846,148.69
3	31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	128,378,875.21	64,846,148.69
4	31210	1.1.1.02.01 Төгрөг	128,378,875.21	64,846,148.69
5	31211	1.1.1.02.01.01 Төрийн сангийн харилцах	128,378,875.21	64,846,148.69
6	35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	124,001,837.18	109,300,218
7	35100	1.1.5.01 Түүхий эд материал	32,906,325	32,875,500
8	35110	1.1.5.01.01 Тусгай зориулалттай материал	32,875,500	32,875,500
9	35130	1.1.5.01.02 Эм боох материал	30,825	0.0
10	35400	1.1.5.04 Хангамжийн материал	91,095,512.18	76,424,718
11	35410	1.1.5.04.01 Бичиг хэргийн материал	1,331,500	1,352,900
12	35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	38,629,634.68	30,675,608.4
13	35430	1.1.5.04.03 Сэлбэг хэрэгсэл	785,000	240,000
14	35460	1.1.5.04.06 Хүнсний материал	12,337,710	9,137,542.1
15	35470	1.1.5.04.07 Бусад хангамжийн материал	38,011,667.5	35,018,667.5
16	2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,326,641,337.52	1,293,138,177.75
17	39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,326,641,337.52	1,293,138,177.75
18	39200	1.2.2.02 Биет хөрөнгө	1,291,345,087.82	1,257,854,428.09
19	39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	1,340,263,493	1,340,263,493
20	39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	-147,797,737.8	-170,135,462.64
21	39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	89,237,010	105,624,510
22	39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	-23,394,409.61	-43,179,631.2
23	39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	46,351,020	49,763,520
24	39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	-21,271,042.69	-29,283,789.91
25	39214	1.2.2.02.14 Бусад үндсэн хөрөнгө	11,487,750	11,487,750
26	39215	1.2.2.02.15 Хуримтлагдсан элэгдэл	-3,726,052.08	-6,881,018.16
27	39217	1.2.2.02.17 Ном	195,057	195,057
28	39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	35,296,249.7	35,283,749.66
29	39301	1.2.2.03.01 Програм хангамж	2,080,000	2,080,000
30	39302	1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл	-1,953,750.3	-1,966,250.34
31	39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	35,170,000	35,170,000
32	3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,579,022,049.91	1,467,284,544.44
33	4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,009,200	13,461,443.5
34	41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,009,200	13,461,443.5
35	41300	2.1.1.03 Өглөг	1,009,200	13,461,443.5
36	41310	2.1.1.03.01 Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	8,221,004.5
37	41320	2.1.1.03.02 Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	595,900
38	41360	2.1.1.03.06 Бусад өглөг	1,009,200	4,644,539
39	41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	1,009,200	2,207,039
40	41362	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	2,437,500
41	5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,578,012,849.91	1,453,823,100.94
42	51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	1,578,012,849.91	1,453,823,100.94
43	51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	241,344,798	241,344,798
44	511002	2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	241,344,798	241,344,798
45	51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	1,110,540,473.39	986,350,724.42
46	51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	981,907,635.95	1,110,540,473.39
47	51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	128,632,837.44	-124,189,748.97

**Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

48	51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,127,578.52	226,127,578.52
49	6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,579,022,049.91	1,467,284,544.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,187,657,070	1,048,786,479
2	12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,482,070	1,048,786,479
3	120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	89,482,070	22,393,379
4	120009	1.1.1.04.1.09 Бусад орлого	0.0	40,579
5	120017	1.1.1.04.1.13 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	58,978,220	19,800,000
6	120018	1.1.1.04.1.14 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30,503,850	2,552,800
7	122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,026,393,100
8	1221	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	0.0	1,026,393,100
9	12211	1.1.1.04.3.01.01 Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,026,393,100
10	122111	1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	1,026,393,100
11	13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,098,175,000	0.0
12	1310	1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	1,098,175,000	0.0
13	131001	1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,098,175,000	0.0
14	II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,059,024,232.56	1,172,976,227.97
15	21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,059,024,232.56	1,172,976,227.97
16	210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,059,024,232.56	1,172,976,227.97
17	2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	769,306,400.48	867,101,197.94
18	210101	1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин	529,480,467.83	564,332,189.67
19	210102	1.1.2.01.1.01.02 Нэмэгдэл	220,535,685.65	230,164,523.17
20	210103	1.1.2.01.1.01.03 Унаа хоолны хөнгөлөлт	0.0	30,568,381.59
21	210104	1.1.2.01.1.01.04 Урамшуулал	19,290,247	42,036,103.51
22	2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,793,927.44	100,365,609.16
23	210201	1.1.2.01.1.02.01 Тэтгэврийн даатгалын зардал	65,591,648.52	65,835,679.13
24	210202	1.1.2.01.1.02.02 Тэтгэмжийн даатгалын зардал	7,736,966.16	9,390,144.45
25	210203	1.1.2.01.1.02.03 ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,852,201.32	4,222,463.22
26	210204	1.1.2.01.1.02.04 Ажилгүйдлийн даатгалын зардал	3,522,620.38	4,166,477.49
27	210205	1.1.2.01.1.02.05 Эрүүл мэндийн даатгалын зардал	14,090,491.06	16,750,844.87
28	2105	1.1.2.01.1.05 Нормативт зардал	114,258,810	94,759,867.9
29	210502	1.1.2.01.1.05.02 Хоол, хүнс	114,258,810	94,759,867.9
30	2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,510,100	2,375,700
31	210806	1.1.2.01.1.08.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,510,100	2,375,700

**Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

32	2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	79,154,994.64	108,373,852.97
33	210901	1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	27,121,035	48,721,793.2
34	210902	1.1.2.01.1.09.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,294,900	6,348,900
35	210903	1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,739,059.64	53,303,159.77
36	III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	128,632,837.44	-124,189,748.97
37	VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	128,632,837.44	-124,189,748.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,098,175,000	1,026,433,679
2	12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	1,026,433,679
3	120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	0.0	40,579
4	120004	1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	40,579
5	1200042	1.1.1.1.04.1.04.02 Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	40,579
6	122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,026,393,100
7	1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	0.0	1,026,393,100
8	12211	1.1.1.1.04.3.01.01 Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,026,393,100
9	122111	1.1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	1,026,393,100
10	13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,098,175,000	0.0
11	1310	1.1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	1,098,175,000	0.0
12	131001	1.1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,098,175,000	0.0
13	II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,017,939,748.41	1,089,966,405.52
14	21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,939,748.41	1,089,966,405.52
15	210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,017,939,748.41	1,089,966,405.52
16	2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	769,306,400.48	871,868,537.33
17	210101	1.1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин	529,480,467.83	569,578,296.17
18	210102	1.1.1.2.01.1.01.02 Нэмэгдэл	220,535,685.65	229,685,757.87
19	210103	1.1.1.2.01.1.01.03 Унаа хоолны хөнгөлөлт	0.0	30,568,381.59
20	210104	1.1.1.2.01.1.01.04 Урамшуулал	19,290,247	42,036,101.7
21	2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,793,927.44	91,411,918.19
22	210201	1.1.1.2.01.1.02.01 Тэтгэврийн даатгалын зардал	65,591,648.52	57,614,674.63
23	210202	1.1.1.2.01.1.02.02 Тэтгэмжийн даатгалын зардал	7,736,966.16	9,390,144.45
24	210203	1.1.1.2.01.1.02.03 ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,852,201.32	4,222,463.22
25	210204	1.1.1.2.01.1.02.04 Ажилгүйдлийн даатгалын зардал	3,522,620.38	4,166,477.49
26	210205	1.1.1.2.01.1.02.05 Эрүүл мэндийн даатгалын зардал	14,090,491.06	16,018,158.4
27	2105	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	110,306,990.49	90,963,800

**Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

28	210502	1.1.1.2.01.1.05.02 Хоол, хүнс	110,306,990.49	90,963,800
29	2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,490,100	2,260,000
30	210806	1.1.1.2.01.1.08.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,490,100	2,260,000
31	2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	41,042,330	33,462,150
32	210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	32,142,430	26,913,450
33	210902	1.1.1.2.01.1.09.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,899,900	6,548,700
34	III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	80,235,251.59	-63,532,726.52
35	V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	27,379,500	0.0
36	22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,379,500	0.0
37	2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	27,379,500	0.0
38	225106	1.1.2.2.01.1.06 Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,379,500	0.0
39	VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-27,379,500	0.0
40	VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	52,855,751.59	-63,532,726.52
41	101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	75,523,123.62	128,378,875.21
42	20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,378,875.21	64,846,148.69
43	99	2 Хамаарахгүй	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
			1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	241,344,798	226,127,578.52	981,907,635.95	1,449,380,012.47
2	3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	241,344,798	226,127,578.52	981,907,635.95	1,449,380,012.47
3	9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	128,632,837.44	128,632,837.44
4	10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	241,344,798	226,127,578.52	1,110,540,473.39	1,578,012,849.91
5	11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	241,344,798	226,127,578.52	1,110,540,473.39	1,578,012,849.91
6	13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	241,344,798	226,127,578.52	1,110,540,473.39	1,578,012,849.91
7	19	1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-124,189,748.97	-124,189,748.97
8	20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	241,344,798	226,127,578.52	986,350,724.42	1,453,823,100.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,027,493,200	1,026,393,100
2	12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,027,493,200	1,026,393,100
3	122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,027,493,200	1,026,393,100
4	122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,027,493,200	1,026,393,100
5	II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,145,026,700	1,089,966,405.52
6	21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,145,026,700	1,089,966,405.52
7	210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,145,026,700	1,089,966,405.52
8	2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	889,814,600	871,868,537.33
9	210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	597,980,500	569,578,296.17
10	210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	254,696,300	229,685,757.87
11	210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	0.0	30,568,381.59
12	210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	37,137,800	42,036,101.7
13	2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,247,700	91,411,918.19
14	210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	74,788,100	57,614,674.63
15	210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	8,864,900	9,390,144.45
16	210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,432,400	4,222,463.22
17	210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,432,400	4,166,477.49
18	210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	17,729,900	16,018,158.4
19	2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	101,639,500	90,963,800
20	210502	3.1.01.2.1.1.5.02 Хоол, хүнс	101,639,500	90,963,800
21	2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,711,300	2,260,000
22	210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,711,300	2,260,000
23	2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	38,613,600	33,462,150
24	210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	29,909,400	26,913,450
25	210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,704,200	6,548,700
26	8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-117,533,500	-63,573,305.52
27	9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	117,533,500	63,573,305.52
28	7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	117,533,500	63,573,305.52
29	4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	128,419,454.21
30	5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	64,846,148.69

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК”-ийн аудитор С.Дарьсүрэн, ахлах аудитор Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэг нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 1,143,864.34 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,157.96 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар 12,868.47 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэх шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 166 мэдээллийг бүрэн оруулж, 5 мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 169 мэдээллийг бүрэн оруулж, 2 мэдээлэл хоцорч мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд хийж гүйцэтгэсэн.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах, таслан зогсоох 3 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

- Тайлант жилд Цэцэрлэгийн хүүхдийн хоолны норм тогтмол бариулаагүй 10 дугаар сард 760.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан, цалингийн тооцоололд сорил гүйцэтгэхэд 2 хүний ажилласан хоногийг илүү тооцож 148.9 мянган төгрөгийн цалин илүү бодож олгосон, ажилчид хувийн ажлаар чөлөө авахад цалинг тооцохдоо тушаал шийдвэргүй цалинтай чөлөөгөөр тооцон 800.0 мянган төгрөгийн цалин илүү бодож олгосон нийт 1,708.97 мянган төгрөгийг зөрчил илэрч төлбөрийн акт
- Тайлант жилд Үнэ төлбөргүй хүлээн авсан 7,800.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 11,503.8 мянган төгрөгийн бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого томиссын тушаал, эмчийн үзлэгт хамрагдсан үзлэгийн тушаалыг зэргийг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй зөрчил илэрч албан шаардлага
- Тайлант онд Цэцэрлэгт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс "гараас гарт" зарчмыг баримтлан хүүхдийг өглөө багшид нь, ажлын дараа эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгдөг бүртгэл хангалтгүй, цэцэрлэгийн хүүхдийн хоолны норм тогтмол бариулаагүй 9 болон 12 дугаар сард 105.3 мянган төгрөгийг илүү зарцуулсан, хүнсний материал худалдан авахдаа тендерийг харьцуулалтын болон шууд худалдан авах аргыг ашигласан гэх боловч тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтлээгүй, хэлэлцээ хийх урилга хүргүүлээгүй тендерийн материал шаардлага хангаагүй тул зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.
- *Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.*

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	1,708.9	3	1,708.9	100.0
Албан шаардлага	1	19,304.0	1	19,304.0	100.0
Зөвлөмж	3	105.3	3	105.3	100.0
Нийт дүн	7	21,118.2	7	21,118.2	100.0

Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийн хэрэгжилтийг биелүүлж ажилласан байна.

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалт
2. Хоол хүнсний материалын худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар илэрсэн нийт 63,785.88 мянган төгрөгийн зөрчилд 3,398.68 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 46,461.03 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 13,926.17 мянган төгрөгийн дахин давтан гаргахгүй 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илэрсэн нийт зөрчилтэй асуудлын материаллаг байдал нь 63,785.88 мянган төгрөг бөгөөд энэ нь гүйцэтгэлийн материаллаг байдал 12,868.47 мянган төгрөгөөс их байгаа “Хязгаарлалттай дүгнэлт” өглөө. Үүнд:

4.1 Төлбөрийн акт

Аудитаар 2 төлбөрийн акт тогтоосон болно.

4.1.1 12 сар дугаар нийт 14 багш нарын илүү цагийг илүү цаг бодох журмын хүрээнд тооцоолоогүй 2 хувиар бодож 0.5 хувиар илүү олгосон 1,418,743.25 төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна

4.1.2 Энхээ Одгэрэл ГЮ77111465 2025 сарын 12 сарын 16-ний өдрөөр тасалбар, Гармаа Одгариг НЬ86093060 2025 оны 12 сарын 19-ний өдрөөр тасалбар болгосон боловч 12 сард бүтэн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; заалтуудтай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

4.2 Албан шаардлага

4.2.1 Цэцэрлэгийн хоол хүнсний материал нэг хүүхдэд ногдох нормыг тогтмол бариулаагүй, бүлгийн журнал хөтлөлт, няравын өдөрлөгийн бүртгэл хөтлөлт зөрүүтэй, гал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тогооны бүртгэл байхгүй, хагас жил, жилийн эцсийн тайлангаар төсвийг илүү зарцуулсан 7,890.3 мянган төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5. “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1. “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

4.2.2 Нэр бүхий 11 бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүст бараа материалын тооцоо нийлсэн акт үлдээгүйгээр өглөг үүсгэсэн ажилласан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т ‘эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах’ гэж заасныг зөрчсөн байна

4.2.3 2025 оны 12 сарын 05-ний өдөр нийт 115 төрлийн бараа материалын данснаас материалыг зүйлийг шууд зарлага гаргасан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, эрхлэгчийн тушаал байхгүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5. “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1. “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

4.2.4 Үндсэн хөрөнгийн шинж агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд орлогод аван тусгасан, ЗДТГ аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн гал тогооны төхөөрөмжийг хүлээн авсан актгүй орлого авах шийдвэргүй 4 сард нийт 21800000 төгрөгнөөс 2 сая төгрөгийн хүлэмжийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5. “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.4. “Хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө”; 25 дугаар зүйлийн 25.1. “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна

4.2.5 Жилийн эцсийн тооллого хийгдээгүй тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тайлан тус бүрийн тайлан орлого зарлага дутуу тайлагнасан сарын тайлангууд гараагүй программд буруу 109300218 тайлагнасан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т ‘тасралтгүй байх’ гэсэн зарчим, 13.1’ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно’ гэж заасантай нийцэхгүй байна.

4.3 Зөвлөмж

4.3.1 1 дүгээр сараас 12 дугаар сарын Нийгмийн даатгалын тайлангаар даатгуулагчийн код алдаа тайлагнасан

Энэ нь Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна

4.3.2 ХХОАТ-ын тайлангийн даатгуулагчын НДШ, цалин хөлсний тооцооны хүснэгт дэх НДШ 12052279.13 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; заалтуудтай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хянг байгуулл шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	
1 дүгээр сараас 12 дугаар сарын Нийгмийн даатгалын тайлангаар даатгуулагчийн код алдаа тайлагнасан	1	1,873.89					1	1,873.89				
ХХОАТ-ын тайлангийн даатгуулагчийн НДШ, цалин хөлсний тооцооны хүснэгт дэх НДШ 12052279.13 төгрөгөөр зөрүүтэй байна.	1	12,052.27						12,052.27				
Жилийн эцсийн тооллого хийгдээгүй тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тайлан тус бүрийн тайлан орлого зарлага дутуу тайлагнасан сарын тайлангууд гараагүй программд буруу 109300218 тайлагнасан	1	-			1			-				
Үндсэн хөрөнгийн шинж агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд орлогод аван тусгасан, ЗДТГ аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн гал тогооны төхөөрөмжийг хүлээн авсан актгүй орлого авах шийдвэргүй 4 сард нийт 21800000 төгрөгнөөс 2 сая төгрөгийн хүлэмжийг бараа материалын дансанд бүртгэсэн байна	1	21,800.0			1		21,800					
2025 оны 12 сарын 05-ний өдөр нийт 115 төрлийн бараа материалын данснаас материалыг зүйлийг шууд зарлага гаргасан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, эрхлэгчийн тушаал байхгүй	1	11,530.2			1		11,530.					
Нэр бүхий 11 бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүст бараа материалын тооцоо нийлсэн акт үлдээгүйгээр өглөг үүсгэсэн ажилласан	1	5,240.4			1		5,240.4					
Цэцэрлэгийн хоол хүнсний материал нэг хүүхдэд ногдох нормыг тогтмол бариулаагүй, бүлгийн журнал хөтлөлт, няравын өдөрлөгийн бүртгэл хөтлөлт зөрүүтэй, гал тогооны бүртгэл байхгүй, хагас жил, жилийн эцсийн тайлангаар төсвийг илүү зарцуулсан	1	7,890.3			1		7,890.3					

**Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

7,890.3 мянган төгрөг байна											
Энхээ Одгэрэл ГЮ77111465 2025 сарын 12 сарын 16-ний өдрөөр тасалбар, Гармаа Одгариг НЬ86093060 2025 оны 12 сарын 19-ний өдрөөр тасалбар болгосон боловч 12 сард бүтэн цалин олгосон байна.	1	1,979,9	1	1,979,9							
12 сар дугаар нийт 14 багш нарын илүү цагийг илүү цаг бодох журмын хүрээнд тооцоолоогүй 2 хувиар бодож 0.5 хувиар илүү олгосон 1,418,743.25 төгрөгийг олгосон.	1	1,418,7	1	1,418,7							
Дүн	9	63,785.8	2	3,398.68	5	46,461	2	13,926.17			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 104 мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээлэл хоцорч мэдээлсэн 64 огт мэдээлээгүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0